



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан Утас:
70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Аудитор: Л.Уранбилэг
Утас: 70593208
Цахим хаяг: Uranbilegl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-----------|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 4 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 5 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| /төгрөгөөр/..... | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 8 |
| 5.1 Төлбөрийн акт..... | 8 |
| 5.2 Албан шаардлага..... | 8 |
| 1. Цалингийн сан, орон тоо батлагдаагүй албан тушаалд 2,848.6 сая төгрөгийн цалин, ажил хавсарсны нэмэгдэл олгосон. | 8 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН
СУМЫН 1-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ПҮРЭВМАА
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд үндсэн хөрөнгө 13.8 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд, орон нутгаас 3.4 сая төгрөг, Боловсролын яамнаас 10.4 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг тус тус бүртгэлд авсан байна.

Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

4826050011

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 67 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 92.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------|-----------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 257,052,476.7 | 170,941,769.5 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 157,814,858.3 | 48,455,862.2 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 157,814,858.3 | 48,455,862.2 |
| 3121 | Төгрөг | 157,814,858.3 | 48,455,862.2 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 136,970,520.8 | 48,455,862.2 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 20,844,337.5 | - |
| 33 | АВЛАГА | - | 14,612,401.1 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 853,163.6 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 13,759,237.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 99,237,618.4 | 107,873,506.1 |
| 351 | Түүхий эд материал | 45,713,978.4 | 47,707,723.9 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 45,713,978.4 | 47,707,723.9 |
| 354 | Хангамжийн материал | 53,523,640.0 | 60,165,782.2 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,175,450.0 | 3,864,400.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,796,240.0 | 38,068,107.0 |
| 35450 | Барилгын засварын материал | 954,000.0 | 8,382,800.0 |
| 35460 | Хүнсний материал | 12,597,950.0 | 9,850,475.2 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,603,605,100.4 | 1,617,390,596.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,603,605,100.4 | 1,617,390,596.6 |
| 392 | Биет хөрөнгө | 1,571,349,100.4 | 1,583,334,596.6 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,673,723,054.0 | 1,673,723,054.0 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (162,784,794.2) | (204,455,594.3) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,457,061.7 | 103,596,851.7 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (42,225,382.5) | (42,108,458.2) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59,323,188.0 | 65,573,188.6 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (43,144,026.4) | (12,994,445.0) |
| 393 | Биет бус хөрөнгө | 32,256,000.0 | 34,056,000.0 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,256,000.0 | 34,056,000.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,860,657,577.2 | 1,788,332,366.2 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,860,657,577.2 | 1,788,332,366.2 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,860,657,577.2 | 1,788,332,366.2 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 157,413,081.9 | 157,413,081.9 |
| 51101 | Өмч: - төрийн | 157,413,081.9 | 157,413,081.9 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,700,815,315.9 | 1,630,919,284.2 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,693,632,636.2 | 1,703,224,678.6 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 7,182,679.7 | (72,305,394.3) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,429,179.3 | - |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,860,657,577.2 | 1,788,332,366.2 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 905,092,843.0 | 966,787,785.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 27,904,343.0 | 96,966,285.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,904,343.0 | 96,966,285.2 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,089,353.0 | 2,865,596.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,089,353.0 | 2,865,596.0 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 7,620,290.0 | 79,298,494.6 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 194,700.0 | 14,802,194.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 877,188,500.0 | 869,821,500.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 797,128,700.0 | 760,242,000.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 797,128,700.0 | 760,242,000.0 |

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нэгдүгээр илэрхийллийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | |
|--------|--|---------------|-----------------|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 80,059,800.0 | 109,579,500.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 80,059,800.0 | 109,579,500.0 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 892,724,587.2 | 1,030,629,513.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 892,724,587.2 | 1,030,629,513.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 892,723,500.8 | 1,002,552,582.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 560,979,165.0 | 666,847,144.3 |
| 210101 | Үндсэн цалин | 405,778,204.0 | 446,762,965.0 |
| 210102 | Нэмэгдэл | 138,949,381.0 | 154,470,368.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 32,842,065.6 |
| 210104 | Урамшуулал | 16,251,580.0 | 32,771,745.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,788,544.9 | 73,996,059.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,865,940.9 | 50,121,423.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,462,617.2 | 6,418,614.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,710,009.0 | 3,719,105.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,504,086.6 | 2,747,383.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,245,891.0 | 10,989,531.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 71,748,727.5 | 76,859,868.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,946,933.5 | 6,540,951.1 |
| 210302 | Түлш, халаалт | 61,961,914.0 | 67,240,223.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,839,880.0 | 3,078,694.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,347,310.0 | 7,883,487.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,687,750.0 | 168,200.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 379,500.0 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,199,610.0 | 2,735,200.0 |
| 210408 | Бараа материал актальсны зардал | 3,080,450.0 | 4,980,087.5 |
| 2105 | Нормативт зардал | 78,358,060.0 | 73,956,547.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 242,690.0 | - |
| 210502 | Хоол, хүнс | 78,115,370.0 | 73,956,547.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,524,700.0 | 4,388,200.0 |
| 210604 | Урсгал засвар | 6,524,700.0 | 4,388,200.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,441,800.0 | 4,048,410.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,441,800.0 | 4,048,410.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,535,193.3 | 94,572,865.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,038,314.0 | 18,257,850.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 63,000.0 | 6,297,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,433,879.3 | 70,018,015.5 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,086.4 | 28,076,931.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 7,174,300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,174,300.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 20,902,631.3 |
| 21303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 20,902,631.3 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,086.4 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,086.4 | - |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 12,368,255.7 | (63,841,728.1) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 8,463,666.2 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 562,666.2 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | - | 7,901,000.0 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (8,463,666.2) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 12,368,255.7 | (72,305,394.3) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 901,184,292.0 | 872,687,096.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 23,995,792.0 | 2,865,596.0 |

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нэгдүгээр ирцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | |
|---------|--|----------------------|------------------------|
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 23,995,792.0 | 2,865,596.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 23,995,792.0 | 2,865,596.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,995,792.0 | 2,865,596.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 877,188,500.0 | 869,821,500.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 797,128,700.0 | 760,242,000.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 797,128,700.0 | 760,242,000.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 80,059,800.0 | 109,579,500.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 80,059,800.0 | 109,579,500.0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 829,134,719.9 | 976,958,592.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 829,134,719.9 | 976,958,592.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 829,133,633.4 | 935,122,423.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 560,979,165.0 | 667,700,307.9 |
| 210101 | Үндсэн цалин | 405,778,204.0 | 447,616,128.6 |
| 210102 | Нэмэгдэл | 138,949,381.0 | 154,470,368.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 32,842,065.6 |
| 210104 | Урамшуулал | 16,251,580.0 | 32,771,745.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,788,544.9 | 73,996,059.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,865,940.9 | 50,121,423.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,462,617.2 | 6,418,614.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,710,009.0 | 3,719,105.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,504,086.6 | 2,747,383.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,245,891.0 | 10,989,531.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,183,813.5 | 76,859,868.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,946,933.5 | 6,540,951.1 |
| 210302 | Түлш, халаалт | 65,397,000.0 | 67,240,223.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,839,880.0 | 3,078,694.4 |
| 2105 | Нормативт зардал | 79,553,350.0 | 67,407,352.0 |
| 210502 | Хоол, хүнс | 79,553,350.0 | 67,407,352.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,874,900.0 | 11,817,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,874,900.0 | 11,817,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,661,800.0 | 4,048,410.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,661,800.0 | 4,048,410.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,092,060.0 | 33,293,425.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,261,360.0 | 25,648,325.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,830,700.0 | 7,645,100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,086.4 | 41,836,168.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 7,174,300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,174,300.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 20,902,631.3 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 20,902,631.3 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,086.4 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,086.4 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 13,759,237.5 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 13,759,237.5 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>72,049,572.0</u> | <u>(104,271,496.1)</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (| 5,851,900.0 | 5,087,500.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,851,900.0 | 5,087,500.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 5,851,900.0 | 5,087,500.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,851,900.0 | 5,087,500.0 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(5,851,900.0)</u> | <u>(5,087,500.0)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 66,197,672.0 | (109,358,996.1) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 91,617,186.2 | 157,814,858.3 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 157,814,858.3 | 48,455,862.2 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 157,413,081.9 | 2,429,179.3 | 1,686,569,041.2 | 1,846,411,302.4 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 157,413,081.9 | 2,429,179.3 | 1,686,569,041.2 | 1,846,411,302.4 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 12,368,255.7 | 12,368,255.7 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 157,413,081.9 | 2,429,179.3 | 1,700,815,315.9 | 1,860,657,577.2 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 157,413,081.9 | 2,429,179.3 | 1,700,815,315.9 | 1,860,657,577.2 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 2,409,362.6 | 2,409,362.6 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 157,413,081.9 | 2,429,179.3 | 1,703,224,678.6 | 1,861,188,920.8 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.0 | -2,429,179.3 | 0.0 | -2,429,179.3 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | (72,305,394.3) | (72,305,394.3) |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 157,413,081.9 | 0.0 | 1,630,919,284.2 | 1,788,332,366.2 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|---------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 994,549,092.0 | 940,299,123.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 994,549,092.0 | 940,299,123.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 987,374,792.0 | 933,124,823.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 683,363,800.0 | 667,700,307.9 |
| 210101 | Үндсэн цалин | 461,182,200.0 | 447,616,128.6 |
| 210102 | Нэмэгдэл | 202,114,200.0 | 154,470,368.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 32,842,065.6 |
| 210104 | Урамшуулал | 20,067,400.0 | 32,771,745.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 85,042,400.0 | 73,996,059.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,707,900.0 | 50,121,423.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,833,600.0 | 6,418,614.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,416,800.0 | 3,719,105.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,416,800.0 | 2,747,383.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,667,300.0 | 10,989,531.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 97,762,500.0 | 76,859,868.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,120,000.0 | 6,540,951.1 |
| 210302 | Түлш, халаалт | 78,642,500.0 | 67,240,223.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,000,000.0 | 3,078,694.4 |
| 2105 | Нормативт зардал | 69,874,300.0 | 67,407,352.0 |
| 210502 | Хоол, хүнс | 69,874,300.0 | 67,407,352.0 |
| 3 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,178,400.0 | |
| 30 | Нэр данс зөрүү төсөл хөтөлбөрийн орлого | 4,178,400.0 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,817,000.0 | 11,817,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 11,817,000.0 | 11,817,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,138,100.0 | 4,048,410.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,138,100.0 | 4,048,410.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,376,692.0 | 31,295,825.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,731,592.0 | 23,650,725.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,645,100.0 | 7,645,100.0 |
| 3 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 42,342,60 | |
| 300001 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 42,342,60 | |

| | | | |
|---------|---|---------------|---------------|
| 300004 | Тендерийн орлогоос зөвхөн тендер зохион байгуулахтай холбогдсон урсгал зардал | | 140,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,174,300.0 | 7,174,300.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,174,300.0 | 7,174,300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,174,300.0 | 7,174,300.0 |
| 131001 | УРСГАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ | 884,969,592.0 | 760,242,000.0 |
| 1320001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутгийн байгууллага | 109,579,500.0 | 88,676,868,6 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,207.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад залруулсан алдаа байхгүй, 4,648.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,559.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоосон.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 6,207.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 1,559.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,648.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нягтлан бодогчид хууль тогтоомжид заагдаагүй балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан **1,559,000.00** (нэг сая таван зуун тавин есөн мянга) төгрөгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/ 15.1.3 дахь /Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “/Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ заалтыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийн дагуу төсвийг хяналттай, үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх төлбөрийн актыг тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Цалингийн сан, орон тоо батлагдаагүй албан тушаалд 2,848.6 сая төгрөгийн цалин, ажил хавсарсны нэмэгдэл олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих/, 16.5.3-т /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т /батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/Интернэтийн төлбөрийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлж эдийн засгийн ангилал зөрчсөн.

2. Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 1,800.0 мянган төгрөгийн 7 шийдвэрийг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (Шилэн дансны зарчим), 4.1.1-д (мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;), 4.1.3-г (тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;), 6 дугаар зүйлийн 6.4-г (Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:), 6.4.8-д (бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;), 7.2 -т (Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.) гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байх хугацаатай 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|--|-------------|----------------|---------------|----------------|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нягтлан бодогчид хууль тогтоомжид заагдаагүй балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон. | 1 | 1,559.0 | 1 | 1,559.0 | - | - | - | - | - | - |
| Цалингийн сан, орон тоо батлагдаагүй албан тушаалд цалин, ажил хавсарсны нэмэгдэл олгосон. | 1 | 2,848.6 | - | - | 1 | 2,848.6 | - | - | - | - |
| Дүн | 2 | 4,407.6 | 1 | 1,559.0 | 1 | 2,848.6 | - | - | - | - |

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл :

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 5 шийдвэрийг мэдээлээгүй. | 1 | 1,800.0 | | | 1 | 1,800.0 | | | | |
| Дүн | 1 | 1,800.0 | | | 1 | 1,800.0 | - | - | - | - |